



## ҮНИЙН ИНДЕКС ТООЦОХ ҮНИЙН САНАЛ АВАХ ТУХАЙ

### УРИЛГА: Орон сууцны үнийн индекс тооцох

Орон сууцны үнийн индексийг тооцох, үнэлэх болон судалгааны ажлыг гүйцэтгэх сонирхолтой судалгааны баг, байгууллагыг холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна. Тус судалгаа нь дараах зорилготой:

- Худалдан борлуулагдаж буй шинэ, хуучин орон сууцны үнийн индекс тооцох;
- Үл хөдлөх хөрөнгийн үнийн өөрчлөлтийг цаг алдалгүй, үнэн зөв тооцох.

### Судалгааны ажлын хамрах хүрээ, бүрдүүлэх материал

Судалгааны хамрах хүрээ	Улаанбаатар хот
Судалгааны объект	• Худалдан борлуулагдаж буй шинэ, хуучин орон сууц
Түүврийн хэмжээ	• 4,000-6,000 ширхэг
Давтамж	• Сар бүр /нийт 12 сар/
Судалгааг гүйцэтгэх хугацаа	• 2017 оны 2 дугаар сараас 2018 оны 2 дугаар сар хүртэл
Гүйцэтгэх ажил, хүлээгдэх үр дүн	• Худалдан борлуулагдаж буй шинэ, хуучин орон сууцны тоон мэдээллийг цуглуулж, зөвшөөрсөн аргачлалын дагуу орон сууцны үнийн индексийг тооцон, үр дүнг олон нийтэд мэдээлэх
Бүрдүүлэх материал	Мэдүүлгээ ирүүлж буй судалгааны баг, байгууллага нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах материалыг ирүүлнэ: <ul style="list-style-type: none"><li>• Судалгаа, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг туршлагатай, судалгааны чиглэлээр томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байсан тухай танилцуулга /2 нүүрээс хэтрэхгүй/;</li><li>• Судалгаа, шинжилгээ хийх, тайлан дүгнэлт боловсруулах чиглэлээр мэргэжлийн боловсон хүчинтэйг нотлох тайлбар, танилцуулга /2 нүүрээс хэтрэхгүй/;</li><li>• Судалгаа хийх аргачлал, түүний давуу талыг тусгасан танилцуулга;</li><li>• Судалгааны ажлыг хийж гүйцэтгэх ажлын хуваарь болон үнийн дэлгэрэнгүй санал.</li></ul>
Нэмэлт шаардлага /бусад/	12 сарын хугацаатай гэрээ байгуулан хамтран ажиллах бөгөөд цаашид 3 жилийн хугацаанд Монголбанкнаас зөвшөөрсөн аргачлалын дагуу орон сууцны үнийн индексийг өөрийн санхүүжилтээр тооцох.

Сонирхсон судалгааны баг, байгууллага нь нэмэлт мэдээллийг 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2017 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хооронд Монголбанкнаас авч болно. Материалаа дор дурдсан хаягаар 2017 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 16:00 цагаас өмнө ирүүлнэ үү.

Хаяг: Бага тойруу 3, 15160  
Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг  
Харилцах утас: 310162